



Инфляцийн тайлан

Хураангуй хувилбар
2018/06

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР:

- 1 Бодлогын хүүг 10 хувьд хэвээр хадгаллаа. Энэ нь инфляцийг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах, эдийн засгийн өсөлтөд үргэлжлэн дэмжлэг үзүүлж, макро эдийн засаг, санхүүгийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилттой нийцтэй болно.
- 2 Монголбанк иргэдийн өрийн дарамтыг хязгаарлаж улмаар санхүүгийн салбарт эрсдэл хуримтлагдахаас сэргийлэх зорилгоор банкнаас олгох иргэдийн хэрэглээний зээлд Өр-орлогын харьцааны дээд хязгаарыг тогтоож, 2019 оны эхнээс мөрдүүлэхээр боллоо.




Инфляци 2018 оны 4-р сарын эцэст Улаанбаатарт 6.7%, улсын хэмжээнд 6.0% байснаар Төв банкны зорилтот түвшинд хадгалагдлаа.

Инфляци

- Хатуу түлш, суудлын автомашин, хүнсний ногоо, согтууруулах ундаа, тамхи, шатахууны үнэ цаг агаар, татварын өөрчлөлтийн нөлөөгөөр нэмэгдэж байна.
- Эрэлтээс өндөр хамааралтай бараа, бүтээгдэхүүн болох хувцас, үйлчилгээ болон зарим хүнсний үнэ өсөлт багатай байв.
- Ханшаас хамаарал өндөртэй импортын барааны үнийн инфляцид үзүүлэх нөлөө агшиж байна.

Инфляци 8.0 хувийн орчимд хадгалагдаж байна...



Эх сурвалж: УСХ




Инфляци төсөөллийн хугацаанд харьцангуй тогтвортой байж, зорилтот түвшний орчимд хадгалагдах төлөвтэй байна.

Инфляцийн төсөөлөл

- 2018 онд 1 удаагийн шинж чанартай нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсийн инфляцид үзүүлэх нөлөө бага байхаар байна.
- Эдийн засгийн сэргэлттэй холбоотой эрэлтийн шинжтэй инфляци алгуур нэмэгдэхээр байна.
- 2019 онд уул уурхайн бус салбарын идэвхжилтэй холбоотойгоор хүнсний бус инфляци бага зэрэг өсөх бол хүнсний инфляци бага зэрэг буурах төсөөлөлтэй байна.

Төсөөлөл



— Инфляцийн зорилт

Эх сурвалж: Монголбанк



ГАДААД СЕКТОР

ГАДААД ЭРЭЛТ

Хэдийгээр ОХУ-ын эдийн өсөлт хүлээлтээс саарсан ч БНХАУ, Евро бүс болон АНУ-ын эдийн засаг хүлээж байснаас давж өссөж гадаад эрэлт нэмэгдэв.




Цаашид БНХАУ-ын эдийн засгийн өсөлт аажмаар саарч гадаад эрэлт буурах хандлагатай байна.

Протекционист бодлого, геополитик, хориг гэх мэт нь ОУ-ын худалдаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ

Дэлхийн эдийн засгийн идэвхжилттэй холбоотой эрэлт сэргэж, нийлүүлэлтийн шинжтэй хүчин зүйлсийн нөлөөгөөр түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдлаа.

2015 онд урт хугацаанд БНХАУ-ын сэргээгдэх эрчим хүчний үйлдвэрлэл өсөх, нийлүүлэлтийн шалтгаантайгаар нүүрс болон төмрийн хүдрийн үнэ буурах хүлээлттэй байна.



ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

2018 оны I улирал

	Гадаад валютын орох урсгал	Гадаад валютын гарах урсгал
Урсгал данс	Экспорт ↑	Импорт ↑ Үйлчилгээний төлбөрүүд ↑ Гадаад зээл, бондын хүүний төлбөр ↑
Санхүүгийн данс	Гадаадын шууд хөрөнгө оруулалт ↑	Бондын үлдэгдэл төлбөр Гадаад зээл ↓ Бэлэн мөнгө, харилцах ↓

Төлбөрийн тэнцэл 2018 оны I улиралд алдагдалтай гарсан ч, алдагдал өмнөх оны мөн үеэс буурсан.

- Валютын орох урсгал:** Экспортын орлого нэмэгдэж, уул уурхайн салбарын хөрөнгө оруулалт үргэлжлэн тэлж, ӨСХ-ийн санхүүжилтүүд орж ирж байна.
- Валютын гарах урсгал:** Эдийн засаг сэргэж, уул уурхайн бүтээн байгуулалт эрчимжсэн, 2017 онд ургац хураалт бага байсан зэргээс үүдэн импорт хурдтай тэлсэн; гадаад зээл, бондын үндсэн болон хүүний төлбөрүүд; үйлчилгээний төлбөрүүд өндөр түвшинд хадгалагдаж буй зэрэг нь гадаад валютын гарах урсгалын дийлэнх хувийг тайлбарлаж байна.


Эрсдэл: Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ, экспортын хэмжээ, тээвэрлэлтэд учирч болзошгүй хязгаарлалтууд, гадаадын шууд хөрөнгө оруулалтын тогтвортой байдал, Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн санхүүжилтүүд ТТ-ийн цаашдын төлөвт гол нөлөөг үзүүлнэ.



БОДИТ СЕКТОР

ДНБ-ий өсөлтөд эзлэх хувь, салбаруудаар

/2018 оны 1-р улиралд ДНБ-ий жилийн өсөлт **6.1%**/




Эх сурвалж: ҮСХ, судлаачийн тооцоолол

- Уул уурхайн томоохон бүтээн байгуулалтын голлох нөлөөгөөр уул уурхайн бус салбар сүүлийн 6 улирал дараалан өсч байгаа ч, тайлант улиралд өсөлтийн хурд саарч 6.8 нэгж хувьд хүрлээ.
- Мал төллөлт оройтож, том малын зүй бус хорогдол өндөр байгаагаас хөдөө аж ахуйн салбар төдийлөн өссөнгүй.
- Тайлант улиралд нүүрсний экспорт буурсантай холбоотойгоор тээврийн салбарын өсөлт -0.1 хувьд хүрчээ.

Хөдөлмөрийн зах зээл

Хөдөлмөрийн захын үндсэн үзүүлэлтүүд



Эх сурвалж: ҮСХ

• Хөдөө аж ахуйн салбарын өсөлт саарсантай холбоотойгоор тус салбарт ажил эрхлэлт буурсан ч хөдөлмөрийн бүтээмж харьцангуй өндөр салбаруудад ажиллагчдын тоо өссөн байна.

• Эдийн засгийн идэвхгүй хүн ам буурснаар хөдөлмөрийн насны хүн ам буурч, ажиллах хүчний оролцооны түвшин болон хөдөлмөр эрхлэлтийн түвшин өсөхөд нөлөөллөө.

• Ажилгүй иргэдийн тоо эдийн засгийн идэвхтэй хүн амын тооноос хурдтай өссөнөөр ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, өндөр түвшинд хадгалагдаж байна.



Төсвийн сектор


Төсвийн орлого, зарлага, гадаад өрийн хэмжээнд эерэг өөрчлөлтүүд ажиглагдаж байна.

Тэнцвэржүүлсэн орлого

Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого бүрдүүлэлт 2018 оны 3 дугаар сарын байдлаар 109.7 хувийн гүйцэтгэлтэй байв.

10.6%
татварын бус

89.4%
татварын орлого



Төсвийн орлого бүрдүүлэлт

Зарим төрлийн импортын бараа бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн болон онцгой албан татварын хэмжээ нэмэгдсэн.

48

импортын барааны онцгой албан татвар


60.7

импортын барааны НӨАТ орлого

38.5

Импортын барааны гаалийн татвар

тэрбум төгрөг



Төсвийн нийт зардал

Төсвийн нийт зардал 1837 тэрбум төгрөгт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 4.4 хувиар өсчээ. Үүний дийлэнхийг хөрөнгийн зардал болон урсгал шилжүүлгийн зардлын өсөлт бүрдүүлэхээр байна.

694

бараа үйлчилгээний зардал


230

хүүний зардал

697

татаас ба шилжүүлэг

тэрбум төгрөг



Төсвийн үзүүлэлтүүд

тэрбум төгрөг	2016			2018		2018,03	
	Гүй.	Бат.	Төлөвлөгөө	Гүй.	%	Гүй.	%
Нийт орлого	7922	7863	8957	1994	111,3		
Ирээдүйн өв сан	358	509	518	117	105,2		
Тогтворжуулалтын сан	326	123	141	66	219,9		
Тэнцвэржүүлсэн орлого	7239	7231	8298	1811	109,7		
Татварын орлого	6303	6269	7272	1618	113,7		
Татварын бус орлого	936	962	1026	193	85,0		
Нийт зардал	8981	9652	9652	1837	68,6		
Анхдагч зардал	7825	8501	8383	1607	69,1		
Хүүний зардал	1156	1151	1269	230	65,3		
Нийт тэнцэл	-1742	-2420	-1354	-26			
ДНБ-д эзлэх хувь	-6,5%	-8,0%	-4,3%	-0,1%			
Анхдагч тэнцэл	-586	-1269	-85	204			
ДНБ-д эзлэх хувь	-2,2%	-4,2%	-0,3%	0,7%			

- 2018 онд нэгдсэн төсвийн алдагдал болон зардлын нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь өнгөрсөн оноос буурч, төсвийн бодлого үргэлжлэн чангарах төлөвтэй байна.
- Төсвийн алдагдал болон дотоод үнэт цаасны эргэн төлөлтийг бага хүүтэй гадаад эх үүсвэрээр санхүүжүүлснээр цаашид хүүгийн төлбөр багасахаар байна.
- Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдэх Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ хуульд заасан хязгаарыг хангаж, буурахаар байна.



МӨНГӨ, САНХҮҮГИЙН СЕКТОР

Мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж, зээл олголт алгуур өсч байгаа ч чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл өндөр хэвээр байна.

Мөнгөний нийлүүлэлт гадаад эх үүсвэр буюу гадаадын шууд хөрөнгө оруулалт, ӨСХ-ийн санхүүжилтүүд болон экспортын орлого нэмэгдэж байгаа нөлөөгөөр нэмэгдэж байна.

Засгийн газар гаргах үнэт цаасны хэмжээгээ бууруулж байгаа нь банкуудын олгох зээлийн хэмжээ болон мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх нөлөө үзүүлж байна.

Бизнесийн зориулалттай гадаад валютын зээл олголт уул уурхай, худалдааны салбарт нэмэгдэж байна.

Иргэд аж ахуйн нэгжүүд валютаас илүү төгрөгийн хадгаламжаа нэмэгдүүлж байна.


Зээлийн чанар худалдааны салбараас бусад салбарт төдийлөн сайжрахгүй байна.

Зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, салбаруудаар

2018 оны I улирал

Хэрэглээний зээл 47.3 хувиар, өрхийн нийт өр өмнөх оны мөн үеэс 18.2 хувиар өсч 9580.3 тэрбум төгрөгт хүрсэн нь банкны салбарын нийт зээлийн 57.6 хувийг бүрдүүлж байна.

Харин дээрх хугацаанд бизнесийн салбарын зээл 1.9 хувиар, сүүлийн 9 улирлын туршид дунджаар 1.5 хувиар өссөн.



Ажлын байр нэмэгдэж, өрхийн орлого дорвитой өсөөгүй үед ирээдүйн орлогыг барьцаалан өрхийн өр, зээлийг хурдацтай нэмэгдүүлснээр:

1. Хэрэглээний зээлийн чанар муудахад санхүүгийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх;
2. Ирээдүйн орлогоо урьдчилан хэрэглэсэн иргэд тодорхой хугацааны дараа хэрэглээгээ хумиж эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэх;
3. Өрхийн өрийн дарамт нэмэгдсэнээр өрийн цикльд орох, түүнээс гарч чадахгүй байх

Хэрэглээний зээлийн өр орлогын харьцаанд дээд хязгаар тогтоох нь дараах ач холбогдолтой:

1. Өрхийн болон хувийн секторын өрийн дарамт өндөр түвшинд хүрсэн өнөө үед бизнесийн идэвхжлийг инфляцийн дарамт үүсгэхгүйгээр дэмжих;
2. Банкууд иргэдэд зээл олгохдоо хүүгээр өрсөлдөж, бизнесийн болон шинээр гаргах хэрэглээний зээлийн хүү буурах нэг нөхцөлийг бүрдүүлэх;
3. Өрхийн орлогын өсөлт өрийн дарамт болж хувирахаас сэргийлэх;
4. Санхүүгийн салбарт хуримтлагдаж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх;
5. Санхүүгийн эх үүсвэрийг бизнесийн зээлд чиглүүлэх;
6. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах гэх мэт.



**Зэрэг
эрсдэлтэй тул**